



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

### “ХААН банк” ХХК-д үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа хавсран эрхлэх нэмэлт тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.3, 63 дугаар зүйлийн 63.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 85/А-106 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 406 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ХААН банк” ХХК-д үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааны төрөл болох үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа хавсран эрхлэх нэмэлт тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгосонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “ХААН банк” ХХК /Жон Белл/-д үүрэг болгосугай.

1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн системийн тасралтгүй байдлыг хангаж, эрсдэлийг хянаж ажиллах;

2/ Хууль тогтоомжид заасны дагуу зохих өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН